

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын Хойд бүс дэх газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/259-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Сүхбаатар сум	Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: Т.Мөнхзул
	Утас: 7036-2442 Цахим хаяг: Munkhzult@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-16
4. Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18-19
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГИХГ	Гадаадын Иргэн, Харьяатын газар
ХЗДХС	Хууль зүй Дотоод Хэргийн Сайд
ХЗДХЯ	Хууль зүй Дотоод Хэргийн Яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213260 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.16 № СЭА-2023/259-НА-СТА-ТШЗ

СЭА-2023/259-НА-СТА-ТШЗ

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ХОЙД БҮС ДЭХ ГАЗРЫН
ДАРГА Б. МӨНХБАТ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 607,128.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 97.0 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсвийг 18,711.5 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 83.0 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол

зардалд 31,607.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 28,188,8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ХНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,505,741.04	102,102,317.40
35	БАРАА МАТЕРИАЛ	64,505,741.04	102,102,317.40
35100	Түүхий эд материал	4,486,351.00	5,305,211.00
35130	Эм боох материал	4,486,351.00	5,305,211.00
35400	Хангамжийн материал	60,019,390.04	96,797,106.40
35410	Бичиг хэргийн материал	1,455,375.00	992,125.00
35420	Аж ахуйн материал	355,100.00	1,794,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,229,000.00	18,201,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,500,500.00	549,000.00
35450	Барилгын засварын материал	225,000.00	225,000.00
35470	Бусад хангамжийн материал	52,254,415.04	75,035,131.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	517,260,263.76	505,049,948.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	517,260,263.76	505,049,948.78
39200	Биет хөрөнгө	271,608,263.76	259,892,948.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,264,054.11	63,264,054.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,158,163.87	-22,587,640.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245,500,000.00	245,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,736,111.08	-80,652,777.72
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	102,936,892.75	101,272,139.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-70,220,601.13	-68,831,985.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,150,034.99	34,514,219.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,127,842.01	-12,585,061.51
39300	Биет бус хөрөнгө	245,652,000.00	245,157,000.00
39301	Программ хангамж	1,980,000.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-990,000.00	-1,485,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	244,662,000.00	244,662,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	581,766,004.80	607,152,266.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	581,766,004.80	607,152,266.18
51	Засгийн газрын хувь оролцоо	581,766,004.80	607,152,266.18
51100	Засгийн газрын оруулсан капитал	244,662,000.00	244,662,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	244,662,000.00	244,662,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	332,319,866.16	357,706,127.54
51210	Өмнөх үеийн үр дүн	165,925,043.91	332,319,866.16
51220	Тайлант үеийн үр дүн	166,394,822.25	25,386,261.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,784,138.64	4,784,138.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	581,766,004.80	607,152,266.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/
 2023.09.30
 2023.09.30
 2023.09.30
 2023.09.30

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	754,538,565.43	706,180,578.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,214,665.43	49,617,378.00
120	Нийтлэг татварын бус орлого	228,214,665.43	49,617,378.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,599,420.00	14,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,599,420.00	14,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	194,482,187.43	0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	32,133,058.00	35,617,378.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	526,323,900.00	656,563,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,323,900.00	607,128,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	526,323,900.00	607,128,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	49,435,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	49,435,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	584,241,936.79	679,924,186.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,241,936.79	679,924,186.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,658,886.52	659,968,620.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,994,206.43	449,773,311.42
210101	Үндсэн цалин	254,459,480.76	270,857,543.16
210102	Нэмэгдэл	78,116,211.89	87,889,053.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,933,034.98	71,232,562.08
210104	Урамшуулал	5,485,478.80	19,794,152.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,590,006.30	56,609,932.67
210201	Тэтгэврийн даатгал	36,234,402.53	36,373,136.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,216,345.47	5,058,899.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,278,259.67	3,547,999.00
210204	Ажилгүйдлийн даатгал	937,441.77	2,311,999.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,923,556.86	9,317,899.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,516,592.00	31,607,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,726,600.00	1,999,100.00
210302	Түлш, халаалт	7,463,425.00	4,305,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,126,600.00	1,085,300.00
210304	Байрны түрээс	21,199,967.00	24,217,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,729,401.00	43,968,205.64
210401	Бичиг хэрэг	5,421,225.00	2,794,240.00
210402	Тээвэр, шатахуун	17,879,955.00	18,126,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,927,535.00	3,989,184.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,020.00	3,279,170.00
210408	Бараа материал акталсны зардал	17,547,666.00	15,779,311.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,706,084.00	4,711,540.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,637,084.00	1,677,840.00
210604	Урсгал засвар	3,069,000.00	3,033,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,597,000.00	1,476,800.00
210702	Дотоод албан томилолт	3,597,000.00	1,476,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,178,335.00	4,949,516.00
210803	Даатгалын үйлчилгээ	341,550.00	348,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,425.00	249,821.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,200.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	129,900.00	178,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,245,260.00	4,084,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,347,261.79	66,871,714.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,068,380.00	4,366,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,673,200.00	1,904,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,605,681.79	60,600,314.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,583,050.27	19,955,565.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,280,000.00	1,244,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,280,000.00	1,244,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,303,050.27	18,711,565.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,303,050.27	18,711,565.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	170,296,628.64	26,256,391.38
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,901,806.39	870,130.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	208,333.39	0
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	3,693,473.00	870,130.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	166,394,822.25	25,386,261.38

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Арт-17
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	526,323,900.00	656,563,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	526,323,900.00	656,563,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,323,900.00	607,128,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	526,323,900.00	607,128,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	49,435,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	49,435,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	521,323,900.00	622,173,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	521,323,900.00	622,173,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,740,849.73	602,217,634.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,994,206.43	449,773,311.42
210101	Үндсэн цалин	254,459,480.76	270,857,543.16
210102	Нэмэгдэл	78,116,211.89	87,889,053.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,933,034.98	71,232,562.08
210104	Урамшуулал	5,485,478.80	19,794,152.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,590,006.30	56,609,932.67
210201	Тэтгэврийн даатгал	36,234,402.53	36,373,136.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,216,345.47	5,058,899.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,278,259.67	3,547,999.00
210204	Ажилгүйдлийн даатгал	937,441.77	2,311,999.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,923,556.86	9,317,899.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,516,592.00	32,207,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,726,600.00	1,999,100.00
210302	Түлш, халаалт	7,463,425.00	4,905,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,126,600.00	1,085,300.00
210304	Байрны түрээс	21,199,967.00	24,217,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,234,320.00	24,398,444.00
210401	Бичиг хэрэг	3,397,400.00	1,864,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,149,385.00	15,815,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,927,535.00	3,989,184.00
210404	Ном, хэвлэл	360,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,400,000.00	2,729,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,199,200.00	25,048,700.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,799,200.00	2,496,700.00
210604	Урсгал засвар	3,400,000.00	22,552,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,597,000.00	1,476,800.00
210702	Дотоод албан томилолт	3,597,000.00	1,476,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,215,975.00	2,242,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	564,000.00	20,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	341,550.00	348,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,425.00	249,821.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,200.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,758,800.00	1,460,750.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90,000.00	75,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,393,550.00	10,460,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,720,350.00	8,876,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,673,200.00	1,584,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,583,050.27	19,955,565.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,280,000.00	1,244,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,280,000.00	1,244,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,303,050.27	18,711,565.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,303,050.27	18,711,565.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,000,000.00	34,390,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,000,000.00	34,390,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	34,390,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	34,390,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,000,000.00	34,390,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,000,000.00	-34,390,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	165,925,043.91	415,371,182.55

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	165,925,043.91	415,371,182.55
9	Тайлант үеийн үр дүн	-	-	166,394,822.25	166,394,822.25
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	332,319,866.16	581,766,004.80
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	332,319,866.16	581,766,004.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	332,319,866.16	581,766,004.80
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	25,386,261.38	25,386,261.38
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	357,706,127.54	607,152,266.18


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	607,128,200.00	588,416,634.09	18,711,565.91	97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	607,128,200.00	588,416,634.09	18,711,565.91	97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,884,200.00	587,172,634.09	18,711,565.91	97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,710,400.00	449,773,311.42	15,937,088.58	97
210101	Үндсэн цалин	277,498,500.00	270,857,543.16	6,640,956.84	98
210102	Нэмэгдэл	91,338,700.00	87,889,053.52	3,449,646.48	96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,936,000.00	71,232,562.08	3,703,437.92	95
210104	Урамшуулал	21,937,200.00	19,794,152.66	2,143,047.34	90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,219,800.00	56,609,932.67	1,609,867.33	97
210201	Тэтгэврийн даатгал	37,983,000.00	36,373,136.67	1,609,863.33	96
210202	Тэтгэмжийн даатгал	5,058,900.00	5,058,899.00		100
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,548,000.00	3,547,999.00		100
210204	Ажилгүйдлийн даатгал	2,312,000.00	2,311,999.00		100
210205	Эрүүл мэндийн даатгал	9,317,900.00	9,317,899.00		100

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,847,000.00	32,207,600.00	639,400.00	98
210301	Гэрэл, цахилгаан	1,999,100.00	1,999,100.00		100
210302	Түлш, халаалт	4,905,300.00	4,905,300.00		100
210303	Цэвэр, бохир ус	1,085,300.00	1,085,300.00		100
210304	Байрны түрээс	24,857,300.00	24,217,900.00	639,400.00	97
2104	Хангамж, бараа материалын зардал	24,503,900.00	24,398,444.00	105,456.00	100
210401	Бичиг хэрэг	1,864,500.00	1,864,500.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	15,816,200.00	15,815,700.00	500.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,093,900.00	3,989,184.00	104,716.00	97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,729,300.00	2,729,060.00	240.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,004,200.00	10,003,700.00	500.00	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,245,100.00	3,245,000.00	100.00	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,496,700.00	2,496,700.00		100
210604	Урсгал засвар	4,262,400.00	4,262,000.00	400.00	100
2107	Томилолт, зочны зардал	1,476,800.00	1,476,800.00		100
210702	Дотоод албан томилолт	1,476,800.00	1,476,800.00		1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,633,300.00	2,242,546.00	390,754.00	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,300.00	20,000.00	1,300.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	272,300.00	0	272,300.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	352,000.00	348,975.00	3,025.00	99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,300.00	249,821.00	111,479.00	1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	0.00	69
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,462,800.00	1,460,750.00	2,050.00	69
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	75,600.00	75,000.00	600.00	69
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,488,800.00	10,460,300.00	28,500.00	69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,904,700.00	8,876,200.00	28,500.00	69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,584,100.00	1,584,100.00		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,244,000.00	1,244,000.00		
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,244,000.00	1,244,000.00		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,244,000.00	1,244,000.00		

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	607,128,200.00	588,416,634.09	18,711,565.91	
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	607,128,200.00	588,416,634.09	607,128,200.00	
310001	Улсын төсвөөс санхүүжих	607,128,200.00	588,416,634.09	607,128,200.00	



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	49,435,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	49,435,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	49,435,000.00
2106	Эд хогшил худалдан авах		49,435,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		11,245,000.00
210601	Тавилга		19,900,000.00
210604	Урсгал засвар		18,290,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	49,435,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	49,435,000.00
131105	ЗГНХ, ЗДНХөрсөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	49,435,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь “Хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай зорчих 2 талт гэрээний хэрэгжилтийг хангах” зорилго тавин ажилласан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдэд тавих хяналтыг хэрэгжүүлэх,
- Иргэний харьяалал, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд ГИХГ-ын Хяналт шалгалт, үнэлгээ, аудитын хэлтсээс хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйцэтгэл аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХЗДХС-ын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар ХЗДХЯ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,956.4 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.


Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		-	-
Бараа материал	64,505.7	102,102.3	37,596.6
Үндсэн хөрөнгө	517,260.3	505,049.9	-12,210.4
Нийт хөрөнгө	581,766.0	607,152.2	25,386.2
Засгийн газрын хувь оролцоо	581,766.0	607,152.2	25,386.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	581,766.0	607,152.2	25,386.2

Бараа материалын дансны үлдэгдэл 102,102.3 мянган төгрөг болж өмнөх оноос 37,596.6 мянган төгрөгөөр өсөхөд дараах ажил гүйлгээнүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- ГИХГ-аас 14,542,4 мянган төгрөгийн нормын хувцас, 21,075.0 мянган төгрөгийн үнэт цаас, бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан,

- Төсвийн хөрөнгөөр 49,852.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, шатахуун, бараа материалыг худалдан авсан,
- 870.1 мянган төгрөгийн бараа материалыг дотоодод шилжүүлсэн,
- 15,779.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан,
- 31,224.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан гэх мэт.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 691,192.4 мянган төгрөг болж өмнөх оноос 25,699.5 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Үнэ төлбөргүйгээр 14,000.0 мянган төгрөгийн автомашины зогсоолыг бүртгэлд нэмсэн
- Төсвийн хөрөнгөөр 3,245.0 мянган төгрөгийн суурин компьютер, принтер , 2,689.5 мянган төгрөгийн тавилга худалдан авсан,
- Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтээр 11,245.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 17,210.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан,
- ТӨБЗГ-ын 2022 оны 708 дугаар тогтоолоор 16,154.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,535.8 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг акталж данснаас хассан зэрэг.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 607,152.2 мянган төгрөг болж 25,386.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 787,736.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 145,217.7 мянган төгрөгөөр бууруулж / цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 34,584.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 19,113.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 58,478.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,536.1 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 6,540.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна. / 642,518.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт цалин, нийгмийн даатгалд төлөх зардлыг 22,376.0 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 5,200.0 мянган төгрөгөөр гэх мэт нийт 35,390.7 мянган төгрөгөөр бууруулж 607,128.2 мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 607,128.2 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 607,128.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 588,416.6 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь 1 орон тоо дутуу ажиллаж цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 17,546.8 мянган төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 639.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 525.4 мянган төгрөгөөр, хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	605,884.2	587,172.6	18,711.6	97.0
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,244.0	1,244.0	-	100.0
	Дүн	607,128.2	588,416.6	18,711.6	97.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.


Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130012408 тоот дансанд Аймгийн Засаг даргын 2022 оны А/475 захирамжаар Сүхбаатар төмөр замын боомтод баригдсан хил хяналтын байгууллагуудын "Нэг цэгийн үйлчилгээний цогцолбор"-т үйл ажиллагаа явуулах болсонтой холбогдуулан техник хэрэгсэл, тавилга эд хогшлын шаардагдах зардалд 49,435.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноос тавилга эд хогшил худалдан авахад 19,900.0 мянган төгрөг, компьютер, тоног төхөөрөмж худалдан авахад 11,245.0 мянган төгрөг, автомашины сэлбэг авахад 18,290.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.



Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 584,241.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,842.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.


4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ГИХГ-ын удирдлагаас “Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах чиглэл”-ийн харьяа албадад өгч ажилласны дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлснээр шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Байгууллагын байр ашиглалттай холбоотой зардалд хэмнэлт гаргаж ажилласан.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай **нийцсэн** гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, холбогдох баримтад хийсэн завсрын үеийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж ажилласан байна.


Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	12,357.1	4	12,357.1	100
Нийт дүн	4	12,357.1	4	12,357.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газар нь 2022 онд иргэн Г.Батбаяртай нийт 14,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий автомашины зогсоолыг түрээсийн нөхцөлөөр худалдан авах гэрээний төлбөрийг барагдуулж, санхүүгийн тайланд орлого авч бүртгэлд тусгасан боловч 36м талбайтай 2 автомашины зогсоол нь улсын бүртгэлд тус байгууллагын нэр дээр бүртгэлгүй байна.

Цаашид автомашины зогсоолыг тухайн байгууллагын нэр дээр улсын
бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай байна.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй бөгөөд нийт 15,328.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 600.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 14,728.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага:

Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсвөөс 600.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дэх "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:


5.2.1 Худалдан авалтын цахим баримттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд нийт 14,728.9 мянган төгрөгийн сэлбэг, тавилга эд хогшил, материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь " ... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/
 4317143998
 10400659056436

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гүйцэтгэсэн	1	600.0			1	600.0							
Цахим баримтыг нэр төрлөөр бус бөөн дүнгээр тусгасан	1	14,728.9					1	14,728.9					
Нийт дүн	2	15,328.9			1	600.0	1	14,728.9					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж						
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Дүн													-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Дүн													
Нийт дүн													